



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 28 өдөр

Дугаар 1/179

Бор-Өндөр сум

**Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5, 6.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь хэсэг, 9.8.1, 9.8.2, дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, Малчны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/207 дугаар тушаал, Мал эмнэлгийн газрын даргын 2025 оны А/42 дугаар тушаал, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны А/436 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээр баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Р.Цэндсүрэн

Нарийн бичгийн дарга

Э.Гуамарал

Гишүүд

И.Энхтуяа

У.Пүрэвсүрэн

Д.Мөнгөнтуяа

Ч.Саруулмөнх

Б.Мөнх-Оргил

Н.Отгонбилэг

Ц.Бат-Эрдэнэ

Ц.Төртүвшин

Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч

Хүйх 5-р багийн Зохион байгуулагч

Бор-Өндөр 1-р багийн Засаг дарга

Холбоо 2-р багийн Засаг дарга

Бумбат 3-р багийн Засаг дарга

Уурхайчин 4-р багийн Засаг дарга

Хүйх 5-р багийн Засаг дарга

Өлгий 6-р багийн Засаг дарга

Ноён Зүлэгт ХХК МЭҮН-ийн захирал, малын эмч

ЭнТэЧи ХХК МЭҮН-ийн захирал, малын эмч

2. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд сумын бүх малыг уг өвчнөөс урьдчилан сэргийлж дархлаажуулах ажлыг 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 22 хоногт багтаан шуурхай зохион байгуулахыг ЭнТэЧи ХХК, Ноён Зүлэгт ХХК мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч (Ц.Төртүвшин, Ц.Бат-Эрдэнэ) нарт даалгасугай.


3. Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх, товлосон цагт бог малыг бүрэн хамруулахыг багийн Засаг дарга (И.Энхтуяа, У.Пүрэвсүрэн, Д.Мөнгөнтуяа, Ч.Саруулмөнх, Б.Мөнх-Оргил, Н.Отгонбилэг) нарт, урьдчилан сэргийлэх

дархлаажуулалтад мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Р.Цэндсүрэн) -д даалгасугай.

4. Дархлаажуулалтын хуваарийг хавсралтаар баталсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Жаргалсайхан)-д, гүйцэтгэлийг вакцинжуулалт дууссанаас хойш 7 хоногийн дотор танилцуулж, тарилгын материалыг дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Р.Цэндсүрэн)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ГАЛБАДРАХ

Бор-Өндөр сумын Засаг даргын
2025 оны 07 дугаар сарын 28-ны
өдрийн ~~2025~~ Захирамжийн хавсралт

ДАРХЛААЖУУЛАЛТЫН

БОР-ӨНДӨР СУМ БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ТӨЛӨВЛӨГӨӨ

№	МЭҮН-ийн нэр	Дархлаажуулах малын тоо					Шаардлагатай вакцин	
		Хонь	Ямаа	Хурга	Ишиг	Нийт	Шингэлэгч /мл/	Вакцин
1	ЭНТЭЧи	6561	8593	2834	4012	22000	22000	22000
2	Ноён зүлэгт	9108	11014	4837	5041	30000	30000	30000
Нийт		15669	19607	7671	9053	52000	52000	52000

ХУВААРЬ ГАРГАСАН
ТАРХВАР ЗҮЙЧ
Р.ЦЭНДСҮРЭН